

2015 оны 12 сарын 31-ний өдрөөр
тасалбар болсон жилийн

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

“МОНГОЛЫН ГЭР БҮЛИЙН САЙН
САЙХНЫ НИЙГЭМЛЭГ”
Төрийн Бус Байгууллага

Агуулга

| | Хуудасны № |
|--------------------------------------------------------------|---------------|
| Санхүүгийн тайланд хүлээх Удирдлагын Хариуцлагын Мэдэгдэл | 2 |
| Байгууллагын талаарх мэдээлэл | 3 |
| Хараат Бус Аудиторын тайлан | 4-5 |
| Санхүүгийн Тайлангууд | 6-9 |
| Санхүүгийн байдлын тайлан | 6 |
| Үр дүнгийн тайлан | 7 |
| Мөнгөн гүйлгээний тайлан | 8 |
| Өмчийн өөрчлөлтийн тайлан | 9 |
| Санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүд | 10-18 |
| Тайлагнагч аж ахуй нэгж | |
| Тайлан бэлтгэсэн үндэслэл | |
| Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй | |
| Санхүүгийн Тайлангийн нэмэлт тодруулгууд | |

**2015 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
санхүүгийн тайлан бэлтгэх болон батлах талаарх
Удирдлагын Хариуцлагын Мэдэгдэл**

Энэхүү тайлангийн 4-5 дахь хуудсанд тусгагдсан хараат бус аудиторын тайланд дурдсан хараат бус аудиторын дүгнэлттэй хамт уншигдах дараах мэдэгдэл нь “Монголын Гэр Бүлийн Сайн Сайхны Нийгэмлэг” Төрийн Бус Байгууллага (“МГБССН ТББ”) 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг тусад нь илэрхийлэх үүднээс хийгдсэн болно.

МГБССН ТББ-ийн удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Монгол улсын Сангийн сайдын 2005 оны 12 сарын 30-ны өдрийн 385 тоот тушаалаар батлагдсан “Төрийн бус байгууллагад мөрдөх НББ-ийн маягт, заавар”-ын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй болно. Бид эдгээр санхүүгийн тайлантай холбоотой үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

МГБССН ТББ-ын 2015 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилүүдийн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрч батлав.

Б.МӨНХЦЭЦЭГ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ч. ГАНБААТАР
САНХҮҮГИЙН МЕНЕЖЕР

Улаанбаатар хот, Монгол улс
Огноо: 2016 оны 04 дугаар сарын 30-ны өдөр

**“Монголын Гэр Бүлийн Сайн Сайхны Нийгэмлэг” ТББ
Байгууллагын талаарх мэдээлэл**

| | | |
|-------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Үүсгэн байгуулах шийдвэр | “Монголын Гэр Бүлийн Сайн Сайхны Нийгэмлэг” /МГБССН/ ТББ нь сайн дурын, төрийн бус байгууллага бөгөөд 1994 онд байгуулагдсан. | |
| Гэрчилгээ ба тусгай зөвшөөрөл | 2013 оны 12 сарын 31-ний өдөр улсын бүртгэлд шинэчлэн бүртгүүлж, 9082611 регистрийн дугаартай 9071042070 улсын бүртгэлийн дугаар бүхий Улсын Бүртгэлийн Гэрчилгээ авсан. | |
| Үндэсний Зөвлөл | Д.Дарханбаяр Э.Гүнжинлхам Д.Давааням Б.Ундармаа Б.Оюун-эрдэнэ Б.Ганболд А.Гэрэлмаа М.Санжаасүрэн Б.Цаямаа Р.Тунгалаг Д.Туяа Э.Цэдэндаш С.Гэрэлмаа Б.Дангаасүрэн | Архангай салбар Баянхонгор салбар Булган Сайхан салбар Дархан-уул салбар Дорноговь салбар Дорнод салбар Сэлэнгэ салбар Орхон салбар Өвөрхангай салбар Өмнөговь салбар Сүхбаатар салбар Төв салбар Увс салбар Улаанбаатар салбар |
| Гүйцэтгэх Удирдлага | Б. Мөнхцэцэг | Гүйцэтгэх Захирал |
| Байнгын хаяг | “МГБССН” ТББ 10-р хороолол, 5-р хороо, 89/3 2 давхар Сонгинохайрхан дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс | |
| Аудитор | БДО Аудит ХХК АБ Центр, 10-р давхар Их сургуулийн гудамж 32/1 Сүхбаатар дүүрэг, 6-р хороо Улаанбаатар-14193, Монгол улс | |

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

**“Монголын Гэр Бүлийн Сайн Сайхны Нийгэмлэг” ТТБ-ын
Үндэсний Зөвлөлд**

Санхүүгийн тайлангийн талаар

Бид “Монголын Гэр Бүлийн Сайн Сайхны Нийгэмлэг” ТТБ-ын 6-18 дүгээр хуудсанд тусгагдсан 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн Санхүүгийн Байдлын Тайлан, энэ өдрөөр тасалбар болсон тайлант жилийн Үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгийн Өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлзээ.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Монгол улсын Сангийн сайдын 2005 оны 12 сарын 30-ны өдрийн 385 тоот тушаалаар батлагдсан “Төрийн бус байгууллагад мөрдөх НББ-ийн маягт, заавар”-ын дагуу бэлтгэж, шударгаар толилуулах, санхүүгийн тайлангуудыг алдаа юмуу заль мэхнээс үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид бэлтгэх боломж бүрдүүлэхэд шаардагдах дотоод хяналтыг удирдлагаас тодорхойлох үүрэг хариуцлагыг хүлээдэг.

Аудиторын хүлээх хариуцлага

Бид гүйцэтгэсэн аудитдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах үүрэгтэй. Бид аудитаа Нягтлан Бодогчдын Олон Улсын Холбооноос гаргасан Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэлээ. Эдгээр стандарт нь санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэсэн зохих нотолгоог олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, ёс зүйн шаардлагуудыг баримтлан гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажил нь санхүүгийн тайлан дахь дүн болон тодруулгын үндэслэлийг тестиийн үндсэн дээр шалгаж батлах ажлыг багтаадаг. Санхүүгийн тайлангууд нь алдаа эсвэл залилангийн улмаас гарч болох материаллаг буруу тайлагналтай байж болох эрсдэлийг үнэлэх зэрэг горимуудыг аудитор өөрийн шийдлээр сонгож авна. Тэдгээр эрсдэлийн үнэлгээг хийхэд байгууллагын дотоод хяналтын системийн үр нөлөөтэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиохын тулд санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, үнэн зөв танилцуулахтай холбоотой дотоод хяналтыг аудитор авч үздэг. Түүнчлэн аудитын ажил нь санхүүгийн тайланг бүхэлд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн тооцооллууд, хэрэглэсэн бүртгэлийн зарчмуудыг шалгах ажлыг өөртөө агуулдаг.

Бидний хийсэн аудитын ажил нь эдгээр санхүүгийн тайланд дүгнэлт гаргах хангалттай үндэслэл болж чадна гэж үзлээ.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ургэлжлэл)

Хязгаарлалтын үндэслэл

Тус ТББ-ын 2014 оны 12-р сарын 31 -ээр тасалбар болсон жилийн санхүүгийн тайланд өөр аудитын компани аудит хийж, 2015 оны 04-р сарын 20-ны өдрөөр огноолсон аудитын тайлангаараа Аудиторын хязгаарлалттай санал дүгнэлт илэрхийлсэн байсан. Бид өмнөх аудиторын хязгаарлалтын үндэслэлийн талаар ямар нэгэн мэдээлэл олж чадаагүй.

Түүнчлэн бид аудитын явцад өмнөх аудитын ажлын баримттай танилцах хүсэлт хүргүүлсэн боловч аудитын тайлан гарахаас өмнө хугацаанд ямар нэгэн хариу ирүүлээгүй бөгөөд бид өөр аудитын горим гүйцэтгэх замаар тус ТББ-ын хөрөнгө, өр төлбөрийн 2015 оны 1-р сарын 1-ний улдэгдэл үнэн бөгөөд бодитой эсэх, зэрэгцүүлэх мэдээлэл нь тайлант жилтэй нийцтэй эсэх, өмнөх жилүүдэд хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь тайлант жилд тогтвортой байсан эсэх талаар хангалттай зохистой аудитын нотолгоо олж авах замаар аудитын зерэг санал дүгнэлт гаргах боломжгүй байсан.

Аудиторын дүгнэлт

Бидний дүгнэлтээр, **Хязгаарлалтын үндэслэл** хэсэгт дурдсан эхний үлдэгдлийн санхүүгийн тайланд үзүүлэх нэлөөллөөс бусад зүйлсийн хувьд, санхүүгийн тайлангууд нь “Монголын Гэр Булийн Сайн Сайхны Нийгэмлэг” ТТБ-ын 2015 оны 12 сарын 31-ний санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Монгол улсын Сангийн сайдын 2005 оны 12 сарын 30-ны өдрийн 385 тоот тушаалаар батлагдсан “Төрийн бус байгууллагад мөрдөх НББ-ийн маягт, заавар”-ын дагуу бүх материаллаг талаараа шударгаар илэрхийлсэн байна.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын “Төрийн Бус Байгууллагын тухай Хууль”-ийн 11-р зүйлд заасан хуулийн этгээд болох “Монголын Гэр Булийн Сайн Сайхны Нийгэмлэг” ТТБ-ын удирдах зөвлөл, бүх гишүүдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.

“БДО Аудит” ХХК
Улаанбаатар хот, Монгол улс
Тусгай зөвшөөрөл: 009-1997

Огноо: 2016/05/11

“МОНГОЛЫН ГЭР БҮЛИЙН САЙН САЙХНЫ НИЙГЭМЛЭГ” ТТБ

2015 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

| | Тэм | 2015 оны 12 сарын 31 мян.төг | 2014 оны 12 сарын 31 мян.төг |
|----------------------------------------|-----|------------------------------------|------------------------------------|
| ХӨРӨНГӨ | | | |
| Эргэлтийн бус хөрөнгө | | | |
| Өмч, Барилга, Тоног төхөөрөмж | 4 | 998,319 | 961,243 |
| Хуримтлагдсан элэгдэл | 4 | (310,078) | (321,709) |
| Биет бус хөрөнгө | 5 | 2,575 | 3,040 |
| Хуримтлагдсан элэгдэл | 5 | (242) | (2,384) |
| Нийт эргэлтийн бус хөрөнгө | | 690,573 | 640,191 |
| Эргэлтийн хөрөнгө | | | |
| Бараа материал | 6 | 53,725 | 149,388 |
| Дансны авлага | 7 | 14,866 | 10,824 |
| Урьдчилж төлсөн төлбөр | | 519 | - |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 8 | 218,201 | 45,566 |
| Нийт эргэлтийн хөрөнгө | | 287,311 | 205,777 |
| НИЙТ ХӨРӨНГӨ | | 977,884 | 845,968 |
| ЦЭВЭР ХӨРӨНГӨ БА ӨР ТӨЛБӨР | | | |
| Цэвэр хөрөнгө | | | |
| Неец Хязгаарлалттай | 9 | 65,186 | 538 |
| Неец Хязгаарлалтгүй | 9 | 818,351 | 871,100 |
| Хуримтлагдсан үр дүн | | - | (38,197) |
| Нийт цэвэр хөрөнгө | | 883,538 | 833,441 |
| Эргэлтийн бус өр төлбөр | | | |
| Үрт хугацаат зээл | 10 | 79,670 | 12,196 |
| Нийт эргэлтийн бус өр төлбөр | | 79,670 | 12,196 |
| Эргэлтийн өр төлбөр | | | |
| Дансны өглөг | 11 | 14,080 | 331 |
| Бусад татварын өглөг | 11 | 596 | - |
| Нийт эргэлтийн өр төлбөр | | 14,676 | 331 |
| НИЙТ ЦЭВЭР ХӨРӨНГӨ БА ӨР ТӨЛБӨР | | 977,884 | 845,968 |

“МОНГОЛЫН ГЭР БҮЛИЙН САЙН САЙХНЫ НИЙГЭМЛЭГ” ТТБ

2015 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

| | Тэм | 2015 он мян.төг | 2014 он мян.төг |
|------------------------------------|-----|--------------------|--------------------|
| Хөтөлбөр, төслийн санхүүжилт | 12 | 635,262 | 582,762 |
| Гишүүдийн татвар | 13 | 1,240 | 1,038 |
| Бэлэг, хандив, тусlamжийн орлого | 14 | 4,097 | 44,260 |
| Түрээсийн орлого | 15 | 6,457 | 9,514 |
| Бусад орлого | 16 | 218,009 | 140,176 |
| Нийт орлогын дүн | | 865,065 | 777,749 |
| Төсөл хэрэгжүүлсэний зардал | 17 | 317,984 | 284,506 |
| Ажиллагсадтай холбоотой зардал | 18 | 243,741 | 240,356 |
| Ерөнхий удирдлагын зардал | 19 | 266,515 | 199,851 |
| Бусад зардал | | 3,045 | 1,356 |
| Нийт зардлын дүн | | 831,285 | 726,069 |
| Бусад олз/гарз/ | 20 | 16,316 | 1,747 |
| Тайлант жилийн цэвэр үр дүн | | 50,096 | 53,427 |

“МОНГОЛЫН ГЭР БҮЛИЙН САЙН САЙХНЫ НИЙГЭМЛЭГ” ТТБ

2015 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

| | 2015 он мян.төг | 2014 он мян.төг |
|-------------------------------------------------------------|--------------------|--------------------|
| Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| Үйл ажиллагааны мөнгөн орлого | 747,562 | 865,065 |
| Гишүүдийн татвараас орсон | 1,038 | 1,240 |
| Төсөл хөтөлбөрөөс хүлээн авсан | 582,762 | 635,262 |
| Бэлэг хандив тусламж | 8,310 | 4,097 |
| Дотоодын өөрийн орлого | 154,089 | 6,457 |
| Бусад | 1,364 | 218,009 |
| Үйл ажиллагааны мөнгөн зарлага | 724,503 | 702,262 |
| Ажиллагчдад олгосон мөнгө | 178,909 | 174,621 |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө | 43,996 | 43,512 |
| Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө | 39,888 | 30,727 |
| Ашиглалтын зардалд төлсөн мөнгө | 22,937 | 20,778 |
| Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө | 18,882 | 27,821 |
| Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн бусад мөнгө | 388,755 | 368,734 |
| Төлсөн хүү | 3,377 | 8,576 |
| Төлсөн татвар | 25,758 | 26,577 |
| Бусад | 2,000 | - |
| Даатгалын төлбөрт төлсөн мөнгө | - | 916 |
| Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ дүн | 23,059 | 162,803 |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| Худалсан урт хугацаат хөрөнгийн орлого | - | - |
| Худалдаж авсан урт хугацаат мөнгөн хөрөнгө | - | - |
| Худалсан хөрөнгө оруулалтын орлого | - | - |
| Худалдаж авсан хөрөнгө оруулалт | - | - |
| Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээний дүн | - | - |
| Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| Банкнаас авсан зээл | - | 79,670 |
| Санхүүгийн түрээсийн өглөгийн төлбөр | - | (79,000) |
| Зээлийг төлөлт | (6,156) | (12,195) |
| Хүү ба урамшуулалтын орлого | 1,675 | 5,042 |
| Валютын ханшийн зөрүү | 1,747 | 16,316 |
| Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээ | (2,734) | 9,833 |
| Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | 20,326 | 172,635 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 25,240 | 45,565 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 45,565 | 218,201 |

**2015 оны 12 сарын 31-ний одроор тасалбар болсон жилийн
ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ОӨРЧЛӨЛТҮЙН ТАЙЛАН**

| Хязгаарлалттай Нөөц ** мян.төг | Хязгаарлалтгүй Нөөц *** мян.төг | Хуримтлагдсан ур дүн мян.төг | Нийт мян.төг |
|--------------------------------------|---------------------------------------|------------------------------------|-----------------|
| 538 | 871,100 | (14,353) | 857,285 |
| - | - | (77,270) | (77,270) |
| 538 | 871,100 | (91,623) | 780,015 |
| - | - | 53,427 | 53,427 |
| 538 | 871,100 | (38,197) | 833,441 |
| 64,648 | (52,748) | 50,096 (11,900) | 50,096 |
| 65,186 | 818,352 | - | 883,538 |

* 2014 онд ТББ нь тайлант жил тус бурийн төтгөлд хуримтлагдсан ур дүнг хязгаарлалттай болон хязгаарлалтгүй нөөцэд сангийн зориулалтаас хамааран хувиарлаж байхаар бодлогоо бөрчилсөн.

** Хязгаарлалттай нөөц дансанд бодино хугацаанд хэрэгжиж байгаа, хязгаарлалттай төслийн цэвэр ур дүнг бүртгэнэ

*** Хязгаарлалтгүй нөөц дансанд урт хугацаанд хэрэгжих эсвэл бусад эх үүсвэрээс бий болсон цэвэр ур дүнг шилжүүлэн бүртгэнэ.

10-18-р хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдэээр санхүүгийн тайллангуудын салишгүй хэсэг болно.

“МОНГОЛЫН ГЭР БҮЛИЙН САЙН САЙХНЫ НИЙГЭМЛЭГ” ТТБ

2015 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ

1. ТАЙЛАГНАГЧ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА

Монголын Гэр Булийн Сайн Сайхны Нийгэмлэг /МГБССН/ нь сайн дурын, төрийн бус байгууллага бөгөөд 1994 онд байгуулагдсан, 1996 оноос эхлэн Олон улсын Гэр Бүл Төвлөлтийн Холбоо (ОУГБТХ)-ны туслах гишүүнээр элсэн орж, 2005 онд жинхэнэ гишүүн болсон. 2006, 2010 онуудад Олон улсад магадлан итгэмжлэгдсэн.

Өвөрхангай аймагт үйл ажиллагаа явуулж байсан нөхөн үржихүйн эмнэлэгэ нь 2015 оны 3-р улиралд үйл ажиллагаагаа зогсоож 2015 оны 12 сарын 31-ний байдлаар нийт 14 салбартай, Улаанбаатар хотод Нөхөн үржихүйн эмнэлэгтэй, Өсвөр үе залуучуудад мэдээлэл, сургалт сурталчилгаа, зөвлөгөө өгөх 8 төвтэй (Орхон, Өвөрхангай, Дорнод, Өмнөговь, Төв, Булган аймгийн Сайхан сум, Архангай аймгийн Хашаат сум, Дорноговь аймаг) нийт 700 гаруй гишүүд, дэмжигчидтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус ТББ нь

- Олон улсын Гэр Бүл Төвлөлтийн Холбоо (ОУГБТХ)
- НҮБ-ын Хүн амын сан

зэрэг олон улсын байгууллагуудтай хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлдэг.

2. ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ҮНДЭСЛЭЛ

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд хэрэглэгдсэн нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын тухай мэдээллийг 3 дугаар тэмдэглэлд оруулсан. Холбогдох хэсэгт тусгайлан зааснаас бусад тохиолдолд тэмдэглэл 3-д заасан бодлогуудыг хэрэглэсээр ирсэн.

ТББ-ын үйл ажиллагааны болон тайлagnagч валют нь Монгол улсын Төгрөг болно. Эдгээр санхүүгийн тайлангууд нь Төгрөгөөр илэрхийлэгдсэн бөгөөд мянган төгрөгөөр нарийвчлан харуулж тайлagnагдсан.

Эдгээр санхүүгийн тайлангууд нь Монгол улсын Сангийн сайдын 2005 оны 12 сарын 30-ны өдрийн 385 тоот тушаалаар батлагдсан “Төрийн бус байгууллагад мөрдөх НББ-ийн маягт, заавар”-ын дагуу бэлтгэгдсэн.

Хэмжилтийн Үндэслэл

Эдгээр санхүүгийн тайлангууд нь бүх зүйлсийн хувьд түүхэн өртөгт суурилан, аккруэл суурийн дагуу бэлтгэгдсэн.

“МОНГОЛЫН ГЭР БҮЛИЙН САЙН САЙХНЫ НИЙГЭМЛЭГ” ТТБ

2015 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ

a. Гадаад валютаарх ажил гүйлгээ

ТББ-ын тайлагнагч валют болон үйл ажиллагааны үндсэн валют нь Монгол улсын Төгрөг юм.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөөрх хөрөнгө, өр төлбөрийг тайлагнах валют (Төгрөг) руу хөрвүүлэхдээ балансын өдрийн албан ханшаар, гадаад валютаар илэрхийлэгдсэн орлого, зарлагуудыг гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар хөрвүүлсэн.

Эдгээр хөрвүүлэлтээс үүссэн ханшийн зөрүүний олз ба гарзыг орлогын тайланд тусгасан.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийг түүхэн өртгөөр нь илэрхийлж гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлсэн.

Тайлант жилийн явцад хэрэглэж байсан ханш дараах байдалтай байна:

| | Хаалтын ханш | |
|---------------------|--------------|----------|
| | 2015 он | 2014 он |
| Ам.доллар ба төгрөг | 1,995.98 | 1,885.60 |

b. Орлого хүлээн зөвшөөрөлт

ТББ-ын орлого нь дараах орлогуудаас бүрдэх ба орлогыг мөнгөөр хүлээн авсан үед нь үр дүнгийн тайланд орлогоор хүлээн зөвшөөрнө.

- (i) Гишүүдийн татвар ба хураамж
- (ii) Хөтөлбөр, төслийн санхүүжилтийн орлого
Санхүүжүүлэгч байгууллагуудтай байгуулсан гэрээний дагуу
- (iii) Түрээсийн орлого
Өвөрхангай болон Орхон аймгуудад байрлах эмнэлэгийн илүү өрөөг эмнэлгийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор түрээсэлдэг.
- (iv) Бэлэг, хандив, тусlamжийн орлого
- (v) Бусад орлого

c. Зардал хүлээн зөвшөөрөлт

Төсөл хөтөлбөрийн зардал нь санхүүжүүлэгч байгууллагуудтай байгуулсан гэрээний дагуу зарцуулалт хийж мөнгөн сууриар зардлыг хүлээн зөвшөөрдөг. Төслийн бус зардлуудыг бусад орлого, бэлэг хандив тусlamжийн орлого болон гишүүний татвараар санхүүжүүлэх ба мөн мөнгөн сууриар зардлыг хүлээн зөвшөөрнө.

d. Нөөц

ТББ-ын нөөц нь хязгаарлалттай ба хязгаарлалтгүй нөөцөөс бүрдэнэ. Хязгаарлалттай нөөц нь санхүүжүүлэгчийн эсвэл хандивлагчийн зүгээс ашиглалтын нөхцөлд нь хязгаарлалт тавьсан нөөц буюу хуримтлагдсан үр дүнг илэрхийлнэ.

Хязгаарлалтгүй нөөц нь төрийн бус байгууллагын бүрэн мэдэлд байгаа өмчийг илэрхийлнэ.

“МОНГОЛЫН ГЭР БҮЛИЙН САЙН САЙХНЫ НИЙГЭМЛЭГ” ТТБ

2015 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

e. Өмч, барилга, тоног төхөөрөмж

Өмч, барилга, тоног төхөөрөмжийг анх өргөөр нь хүлээн зөвшөөрнө. Өмч, барилга, тоног төхөөрөмжийн өртөг нь худалдан авалтын үнээс гадна шууд холбогдсон зардлуудыг тооцоолж бүртгэнэ.

Өмч, барилга, тоног төхөөрөмжүүдийг шулуун шугамын аргаар элэгдүүлэх бөгөөд ашиглахаар тогтоосон хугацаа нь дараах байдалтай байна:

| | |
|----------------------------|----------|
| ▪ Барилга, байгууламж | 30 жил |
| ▪ Компьютер түүний эд анги | 5 жил |
| ▪ Тавилга, эд хогшил | 12 жил |
| ▪ Тээврийн хэрэгсэл | 6 жил |
| ▪ Биет бус хөрөнгө | 15 жил |
| ▪ Бусад үндсэн хөрөнгө | 3-12 жил |

f. Татварын зардал

Татварын зардал нь тайлант жилийн хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн татварын зардлаас бүрдэх бөгөөд Олон Улсын Гэр Бүл Төлөвлөлтийн Холбооны Санхүүжилттэй Захиргаа Аж Ахуй төслөөс энэ зардлыг санхүүжүүлдэг тул орлогын тайланд төсөл хэрэгжүүлэлтийн зардал хэсэгт тусгагддаг.

g. Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгүүд нь бэлэн мөнгө болон бусад банкны байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгөөс бүрдэнэ.

h. Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгө нь тайлант хугацаанд эзэмшиж буй програм хангамж болон газар эзэмших эрхээс бүрдэнэ.

i. Бараа материал

Бараа материал нь мэдээлэл сургалтын тараах материал болон эм эмнэлэгийн материаллаас бүрдэнэ. Бараа материалыг байнгын системээр бүртгэдэг.

j. Авлага

Авлага санхүүжүүлэгч байгууллага, ТББ-ын гишүүн эсвэл гуравдагч талтай үүссэн авлагаас үүсэх бөгөөд удирдах зөвлөлийн хурлын шийдвэрээр авлагыг найдваргүйд тооцож данснаас хасдаг.

k. Шагнал урамшуулал нэмэгдэл цалин

ТББ-ын дотоод журмын дагуу ажилласан жилийн нэмэгдэл болон хортой нөхцөлд ажилласны нэмэгдлүүдийг тооцож олгодог.

“МОНГОЛЫН ГЭР БҮЛИЙН САЙН САЙХНЫ НИЙГЭМЛЭГ” ТТБ

**2015 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)**

4. ӨМЧ, БАРИЛГА, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

| | Барилга, байгууламж | Тээврийн хэрэгсэл | Компьютер тавилга эд хогшил | Нийт |
|--------------------------------------|------------------------|----------------------|-----------------------------------|----------|
| | | | мян.төг | мян.төг |
| Дансны өртөг | | | | |
| 2014 оны 01 сарын 01-ний үлдэгдэл | 602,581 | 69,465 | 257,442 | 929,487 |
| Худалдан авсан | - | - | 31,756 | 31,756 |
| Худалдсан | - | - | - | - |
| 2014 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 602,581 | 69,465 | 289,198 | 961,243 |
| Худалдан авсан | 20,000 | 27,000 | 95,035 | 142,035 |
| Худалдсан | (22,070) | (67,813) | - | (89,883) |
| Данснаас хассан | - | - | (15,077) | (15,077) |
| 2015 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 600,511 | 28,652 | 369,155 | 998,319 |
| Хуримтлагдсан элэгдэл | | | | |
| 2014 оны 01 сарын 01-ний үлдэгдэл | 76,233 | 39,258 | 147,333 | 262,824 |
| Тайлант жилд байгуулсан | 20,542 | 11,577 | 26,765 | 58,885 |
| Худалдсан | - | - | - | - |
| Данснаас хассан | - | - | - | - |
| 2014 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 96,775 | 50,835 | 174,099 | 321,709 |
| Тайлант жилд байгуулсан | 20,530 | 13,252 | 31,703 | 65,485 |
| Худалдсан | (5,592) | (58,394) | - | (63,986) |
| Данснаас хассан | - | - | (13,130) | (13,130) |
| 2015 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 111,713 | 5,693 | 192,672 | 310,078 |
| Цэвэр дансны үнэ | | | | |
| 2014 оны 01 сарын 01-нээр | 526,348 | 30,207 | 110,109 | 666,663 |
| 2014 оны 12 сарын 31-нээр | 505,806 | 18,629 | 115,099 | 639,535 |
| 2015 оны 12 сарын 31-нээр | 488,798 | 22,959 | 176,484 | 688,240 |

“МОНГОЛЫН ГЭР БҮЛИЙН САЙН САЙХНЫ НИЙГЭМЛЭГ” ТТБ

2015 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

5. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

| | Газар эзэмших эрх мян.төг | Программ хангамж мян.төг | Нийт дүн мян.төг |
|-----------------------------------|---------------------------------|--------------------------------|---------------------|
| Өртөг | | | |
| 2014 оны 01 сарын 01-ний үлдэгдэл | 1,040 | 2,000 | 3,040 |
| Нэмэгдсэн | | | |
| 2014 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 1,040 | 2,000 | 3,040 |
| Нэмэгдсэн | - | 2,035 | 2,035 |
| Хасагдсан | (500) | (2,000) | (2,500) |
| 2015 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 540 | 2,035 | 2,575 |
| Хуримтлуулсан хорогдуулалт | | | |
| 2014 оны 01 сарын 01-ний үлдэгдэл | 314 | 2,001 | 2,314 |
| Нэмэгдсэн | 69 | - | 69 |
| 2014 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 383 | 2,001 | 2,384 |
| Нэмэгдсэн | 36 | 56 | 92 |
| Хасагдсан | (233) | (2,000) | (2,233) |
| 2015 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 186 | 56 | 242 |
| Дансны цэвэр үнэ | | | |
| 2014 оны 01 сарын 01-нээр | 726 | - | 726 |
| 2014 оны 12 сарын 31-нээр | 657 | - | 657 |
| 2015 оны 12 сарын 31-нээр | 354 | 1,978 | 2,332 |

6. БАРАА МАТЕРИАЛ

| | 2015 оны 12 сарын 31 мян.төг | 2014 оны 12 сарын 31 мян.төг |
|----------------|------------------------------------|------------------------------------|
| MMC-ийн тайлан | 42,855 | 120,692 |
| Эм | 10,870 | 28,696 |
| | 53,725 | 149,388 |

“МОНГОЛЫН ГЭР БҮЛИЙН САЙН САЙХНЫ НИЙГЭМЛЭГ” ТТБ

2015 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

7. АВЛАГА

| | 2015 оны 12 сарын 31 мян.төг | 2014 оны 12 сарын 31 мян.төг |
|------------------------------------|------------------------------------|------------------------------------|
| 12 сараас дээш 0-12 сар хүртэлх | 8,154 6,712 | 10,824 |
| | <hr/> 14,866 | <hr/> 10,824 |

8. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

| | 2015 оны 12 сарын 31 мян.төг | 2014 оны 12 сарын 31 мян.төг |
|-------------------------------|------------------------------------|------------------------------------|
| Банкин дахь харилцах (төгрөг) | 77,713 | 8,293 |
| Банкин дахь харилцах (валют) | 17,214 | 37,273 |
| Хугацаатай хадгаламжийн данс | 123,274 | - |
| | <hr/> 218,201 | <hr/> 45,566 |

9. ЦЭВЭР ХӨРӨНГӨ

| | Хязгаарлалттай нөөц | Хязгаарлалтгүй нөөц |
|----------------------------------------------|------------------------|------------------------|
| | мян.төг | мян.төг |
| 2014 оны 12 сарын 31-нээр | 538 | 871,100 |
| Өмнөх оны хуримтлгdsan үр дүнгийн хувиарлалт | | (38,197) |
| Тайлан үеийн цэвэр үр дүн | 11,900 | 38,197 |
| Нөөцийн дахин ангилал ба нөөцийн хуварилалт | 52,748 | (52,748) |
| 2015 оны 12 сарын 31-нээр | <hr/> 65,186 | <hr/> 818,352 |

“МОНГОЛЫН ГЭР БҮЛИЙН САЙН САЙХНЫ НИЙГЭМЛЭГ” ТТБ

2015 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

10. УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

| | Урт хугацаат зээл мян.төг |
|------------------------------------|---------------------------------|
| 2014 оны 01 сарын 01-ээрх үлдэгдэл | 18,351 |
| Нэмэгдсэн Эргэн төлөгдсөн | (6,156) |
| | <hr/> |
| 2014 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл | 12,195 |
| Нэмэгдсэн Эргэн төлөгдсөн | 158,670 (91,195) |
| | <hr/> |
| 2015 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл | 79,670 |
| | <hr/> <hr/> |

11. БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

| | 2015 оны 12 сарын 31 мян.төг | 2014 оны 12 сарын 31 мян.төг |
|---------------------------------------------------|------------------------------------|------------------------------------|
| Бусад байгууллага хүмүүст өглөг Татварын өглөг | 14,080 596 | 331 |
| | <hr/> | <hr/> |
| | 14,676 | 331 |
| | <hr/> | <hr/> |

12. ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

| | 2015 он мян.төг | 2014 он мян.төг |
|---------------|--------------------|--------------------|
| IPPF - ESEAOR | 324,252 | 254,719 |
| SAAF | 118,833 | 135,511 |
| UNFPA | 192,177 | 192,531 |
| | <hr/> | <hr/> |
| | 635,262 | 582,762 |
| | <hr/> | <hr/> |

13. ГИШҮҮДИЙН ТАТВАР

| | 2015 он мян.төг | 2014 он мян.төг |
|----------------------------------------------------|--------------------|--------------------|
| Онцгой гишүүдийн татвар Энгийн гишүүдийн татвар | 610 630 | 850 188 |
| | <hr/> | <hr/> |
| | 1,240 | 1,038 |
| | <hr/> | <hr/> |

“МОНГОЛЫН ГЭР БҮЛИЙН САЙН САЙХНЫ НИЙГЭМЛЭГ” ТТБ

2015 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

14. ТҮРЭЭСИЙН ОРЛОГО

Энэ орлого нь Өвөрхангай болон Орхон аймгуудад байрлалтай нөхөн үржихүйн эмнэлэгийн ТББ-ын хэрэгцээнд ашиглаагүй талбайг түрээсэлж олсон орлого болно.

15. БЭЛЭГ ХАНДИВ ТУСЛАМЖИЙН ОРЛОГО

| | 2015 он мян.төг | 2014 он мян.төг |
|-------------------------------|--------------------|---------------------|
| JOICFP | 4,097 | 16,805 |
| Мари Стопс ОУБ | - | 6,745 |
| Дорнод Улаан Загалмайн Холбоо | - | 2,500 |
| Хувь хүмүүс | - | 18,209 |
| | <hr/> 4,097 | <hr/> 44,260 |

16. БУСАД ОРЛОГО

| | 2015 он мян.төг | 2014 он мян.төг |
|----------------------------------------------------------------|----------------------|----------------------|
| Нөхөн үржихүйн эмнэлэгийн орлого | 125,412 | 131,742 |
| Теслүүдийн менежментийн үйл ажиллагаанд зориулсан санхүүжилт | 34,762 | 5,395 |
| Үндсэн хөрөнгө болон хандивын бараа материал борлуулсны орлого | 51,942 | |
| Хүүний орлого | 5,042 | 1,675 |
| Сургалт болон бусад дэмжих үйл ажиллагаанаас олсон орлого | 852 | 1,364 |
| | <hr/> 218,009 | <hr/> 140,176 |

17. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛСНИЙ ЗАРДАЛ

| | 2015 он мян.төг | 2014 он мян.төг |
|---------------------------------------|----------------------|----------------------|
| IPPF - ESEAOR -ийн дэд төслийн зардал | 133,021 | 139,834 |
| SAAF -ийн дэд төслийн зардал | 41,950 | 45,681 |
| UNFPA -ийн дэд төслийн зардал | 143,013 | 98,991 |
| | <hr/> 317,984 | <hr/> 284,506 |

“МОНГОЛЫН ГЭР БҮЛИЙН САЙН САЙХНЫ НИЙГЭМЛЭГ” ТТБ

2015 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

18. АЖИЛЛАГСАДТАЙ ХОЛБООТОЙ ЗАРДАЛ

| | 2015 он мян.төг | 2014 он мян.төг |
|------------------------------------------------------------------------|--------------------|--------------------|
| Ажилчдад олгосон мөнгө Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө | 220,042 23,699 | 217,272 23,084 |
| | 243,741 | 240,356 |

19. ЕРӨНХИЙ УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

| | 2015 он мян.төг | 2014 он мян.төг |
|----------------------------|--------------------|--------------------|
| Ашиглалтын зардал | 20,578 | 22,937 |
| Засвар үйлчилгээний зардал | 1,148 | 8,842 |
| Элэгдлийн зардал | 65,578 | 53,904 |
| Албан томилолтын зардал | 30,260 | 6,102 |
| Зар сурталчилгааны зардал | 104,857 | 65,055 |
| Шуудан, холбооны зардал | 5,197 | 5,727 |
| Шатахууны зардал | 27,821 | 18,882 |
| Шагнал, урамшууллын зардал | - | 13,025 |
| Зээлийн хүүгийн зардал | 8,576 | 3,377 |
| Хандив тусlamжийн зардал | 2,500 | 2,001 |
| | 266,515 | 199,851 |

20. БУСАД ОЛЗ/ ГАРЗ

Энэ нь төслийн санхүүжилтийн санхүүжилтийн гэрээний дагуу гэрээний албан ханшаар хөрвүүлэх эсвэл гадаад вальютаарх гүйлгээг хөвүүлэх үед үүссэн олз эсвэл гарз юм.

21. ЗЭРЭГЦҮҮЛЭХ ҮЗҮҮЛЭЛТ

Тайлант жилийн тайлагналтай нийцүүлэх үүднээс тодорхой зарим зэрэгцүүлсэн үзүүлэлтүүдийг дахин ангилсан болно.

22. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ

Санхүүгийн тайлангийн өдөр болон санхүүгийн тайланг бэлтгэсэн өдрийн хооронд тохиолдсон, томоохон өөрчлөлт, үйл явдал гараагүй болно.

23. ОРЧУУЛГА

Эдгээр санхүүгийн тайлангууд нь Монгол болон Англи хэл дээр бэлтгэсэн болно. Монгол, Англи хувилбаруудын хооронд утга агуулгын зөрүү гарах тохиолдолд Монгол хэл дээрх хувилбарыг баримтална.